



# COMMONWEALTH of VIRGINIA

Department of Medical Assistance Services

CYNTHIA B. JONES  
DIRECTOR

SUITE 1300  
600 EAST BROAD STREET  
RICHMOND, VA23219  
804/786-7933  
800/343-0634 (TOO)  
[www.dmas.virginia.gov](http://www.dmas.virginia.gov)

2015 оны 09 сарын 01

Эцэг эх/ асран хамгаалагч танаа:

Сургуулиас хүүхдийн эмчилгээ үйлчилгээтэй холбогдох зардлыг Medicaid болон Family Access to Medical Insurance (FAMIS) хөтөлбөрүүдээс гаргуулахаар нэхэмжлэл илгээхийн тулд эцэг эхийн зөвшөөрлийг авахаар энэ захидлыг илгээж байна.

Хэрэв танай хүүхэд одоо юм уу хожим “Medicaid” юм уу эсвэл “Family Access to Medical Insurance (FAMIS)” хөтөлбөрт хамрагдах эрх үүссэн, эсвэл ганцаарчилсан сургалтын хөтөлбөр (IEP)-т заасанчлан эрүүл мэндийн үйлчилгээ авсан нөхцөлд Холбооны Засгийн Газраас сургуулиудад эдгээр эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой зардлуудыг санхүүжүүлэхэд тусламж үзүүлдэг юм. Эрүүл мэндийн холбогдолтой үйлчилгээ гэдэгт биеийн ерөнхий эмчилгээ, мэргэжлийн сэргээн засах болон хэл заслийн эмчилгээ, хэл авиан зүйн засал, сувилгаа, сэтгэцийн болон бусад хувийн асаргаа болон Эрт насанд оношилж эмчлэх Хөтөлбөрийн хүрээнд хийх оношлогооны шинжилгээ үйлчилгээг ойлгоно. Мөн дээр дурьдсан эмчилгээ үйлчилгээг авах хугацааны тусгай мэргэжлийн тээврийн үйлчилгээ мөн багтаж болно.

Тиймээс сургуулийн зүгээс Medicaid юм уу FAMIS хөтөлбөрт хүүхдийн эрүүл мэндийн холбогдолтой үйлчилгээний зардлыг гаргуулахаар нэхэмжлэл илгээхийн тулд эцэг эхийн зөвшөөрөл хэрэгтэй болдог. IEP хөтөлбөрт хамрагдаж буй бүх хүүхдүүдээс энэ зөвшөөрлийг урьдчилж авснаар хүүхдүүдийн эмчилгээ үйлчилгээтэй холбоотой зардлын санхүүжилт зөвхөн орон нутгийн татвар төлөгчдийн сангаар хязгаарлагдахгүй холбооны Засгийн газрын хөрөнгөөр санхүүжих боломж бүрддэг.

Хэдий тийм боловч энэ зөвшөөрөлд гарын үсэг зураг эсэх нь зөвхөн таны сайн дурын шийдвэр ба хэрэв зөвшөөрсөн нөхцөлд тухайн зөвшөөрлийг зөвхөн төрөөс санхүүждэг даатгалд нэхэмжлэл илгээх зориулалтаар ашиглах болно. Харин сургууль тухайн эцэг эхийн хувийн даатгалд нэхэмжлэл илгээхгүй. Танай хүүхдийн сургуулиас гадна авсан эрүүл мэндийн эмчилгээ үйлчилгээ нь Medicaid юм уу FAMIS хөтөлбөрт хамаарахгүйг анхаарна уу. Энэ зөвшөөрөлд гарын үсэг зураагүй нь таны хүүхдийн авах эрхтэй эмчилгээ үйлчилгээнд нөлөөлөхгүй. Төрийн Ерөнхий боловсролын сургууль нь бүх нийтэд төрөөс үзүүлэх үнэгүй боловсролын үйлчилгээг тасралтгүй хүргэх үүрэгтэй бол үүнд IEP үйлчилгээ мөн хамаарах юм.

Тусгай боловсролын үйлчилгээг төрийн даатгалын компаниар санхүүжүүлэх нь төрийн ерөнхий боловсролын сургуулийн санхүүжилтийн чухал хэсэг болдог билээ. Та бүхний тусламж дэмжлэгт баярлалаа. Хэрэв энэ талаар ямар нэгэн асуулт байгаа бол Эрүүл Мэндийн тусламж үйлчилгээний Газрын Tabitha Taylor-тай 804-225-3231 тоот утсаар холбогдоно уу.

Хүндэтгэсэн,

  
Cindi B. Jones, Захирал